



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2009 оны хоёрдугаар сарын 13

№6 (579)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|-----|--|----|
| 29. | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 85 |
| 30. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 86 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|-----------|----|
| 11. | Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 17 | 94 |
| 12. | Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох тухай | Дугаар 18 | 94 |
| 13. | Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 19 | 94 |
| 4. | Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай | Дугаар 20 | 94 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | |
|----|--|----|
| 5. | Гадаадын албан ёсны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц | 95 |
|----|--|----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

9 оны 01 дүгээр
ын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн дахь заалтын "гавьяат болон" гэснийг, мөн зүйлийн валлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9 5.1.11 дэх заалтын "-5.1.9" гэснийг тус тус хассугай валтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5.1.9. ахмад дайчин, түүнчлэн ид оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр / р/-т сар бүр мөнгөн тусламж үзүүлэх;"

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн валлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА
Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаа хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 8, 9, 11, 13, 15, 16, 26, 31, 33, 35 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 3-23 дахь хэсэг:

"3. Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагыг 600000-800000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр тус тус торгоно.

4. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчсөн хуулийн этгээдийг 500000-800000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр тус тус торгоно.

5. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 5, 8, 10 дахь хэсэгт заасныг зөрчсөн намыг 800000-1000000 төгрөгөөр торгох ба мөн зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан данснаас гадуур авсан хөрөнгийг хурааж улсын орлого болгоно. Хэрэв уг данснаас гадуур авсан хөрөнгийг зарцуулсан бол түүнийг нөхөн төлүүлж улсын орлого болгоно.

6. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 6, 9 дэх хэсэгт заасныг зөрчсөн хандивлагч, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 200000-300000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, намыг 800000-1000000 төгрөгөөр торгох ба мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасан этгээдээс авсан хандивыг хурааж улсын орлого болгоно.

7. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг зөрчсөн намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 250000-300000 төгрөгөөр, намыг 800000-1000000 төгрөгөөр тус тус торгоно.

8. Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг зөрчсөн төрийн албан хаагчид Цагдаагийн байгууллагын тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах ба бусад албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр торгоно.

9. Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэгт заасныг зөрчсөн иргэнийг 200000-300000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, байгууллагыг 600000-800000 төгрөгөөр тус тус торгоно.

10. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн Засаг даргыг 250000-300000 төгрөгөөр, цагдаа, эмнэлэг, амралт, сувиллын газрын албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, мөн зүйлийн 6 дахь хэсэгт

заасныг зөрчсөн буруутай этгээдийг 200000-300 төгрөгөөр тус тус торгоно.

11. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 7, 11 дэх хэсэгт заасныг зөрчсөн сонгуулийн хороо дарга, нарийн бичгийн даргыг 250000-300 төгрөгөөр, гишүүнийг 150000-200000 төгрөгөөр тус тус торгоно.

12. Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 хэсэгт заасныг зөрчсөн албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, байгууллагыг 500000-800 төгрөгөөр тус тус торгоно.

13. Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 3 д хэсэгт заасныг зөрчсөн төрийн албан хааг Цагдаагийн байгууллагын тухай, Прокурор байгууллагын тухай, Шүүхийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах ба бусад ал тушаалтныг 250000-300000 төгрөгөөр торгоно.

14. Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 4 хэсэгт заасныг зөрчсөн албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, иргэнийг 200000-300 төгрөгөөр, байгууллагыг 500000-800000 төгрөг тус тус торгоно.

15. Энэ хуулийн 28 дугаар зүйлийн 2, 3 д хэсэгт заасныг зөрчсөн хэвлэл мэдээлэл байгууллагыг 800000-1000000 төгрөгөөр, зүйлийн 5 дахь хэсэгт заасныг зөрчсөн иргэ 200000-300000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, намын сонгууль эрхэг байгууллагын ажилтныг 250000-300000 төгрөг байгууллагыг 500000-800000 төгрөгөөр тус торгоно.

16. Энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 2 д хэсэгт заасныг зөрчсөн Засаг даргыг 300000-350 төгрөгөөр торгоно.

17. Энэ хуулийн 30 дугаар зүйлийн 2 д хэсэгт заасныг зөрчсөн Засаг даргыг 300000-350 төгрөгөөр торгоно.

18. Энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 6 д хэсэгт заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөг гишүүнийг 150000-200000 төгрөгөөр тус тус тор

19. Энэ хуулийн 32 дугаар зүйлийн 1-6, хэсэгт заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөг гишүүнийг 150000-200000 төгрөгөөр, мөн зүйл дахь хэсэгт заасныг зөрчсөн иргэнийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-250 төгрөгөөр тус тус торгоно.

20. Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1, 6 дахь зэргт заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, үүнийг 150000-200000 төгрөгөөр, мөн зүйлийн 7 ы хэсэгт заасныг зөрчсөн албан тушаалтныг 1000-250000 төгрөгөөр, байгууллагыг 600000-1000 төгрөгөөр тус тус торгоно.

21. Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан ал тоолох журмыг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр тус тус торгоно.

22. Сонгуулийн хороонд ажиллахаар илгогдсон иргэн үүрэгт ажлаа зохих ёсоор гүүлээгүй бол түүнийг 200000-250000 төгрөгөөр тоно.

23. Энэ хуульд заасан захиргааны ёгтгэлийг сум буюу сум дундын дүүргийн хийн шүүгч нэгдуулах ба түүнд дахь заалдсан длыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх й хуульд заасны дагуу сум буюу сум дундын, згийн шүүх хянан шийдвэрлэнэ."

2/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит уулийн санал хураах өдөр нь сонгуулийн ийн тавдугаар сарын сүүлийн хагасын аль нэг ро хоногийн ням гариг байна."

3/11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"3. Бүх шатны сонгуулийн хороодын ндэхүүн, үйл ажиллагаанд дараахь зарчмыг длөг болгоно:

1/сонгуулийн хороодын дарга, ийн бичгийн дарга нэг намын гишүүн байхыг глгох;

2/сонгуулийн хороодын ндэхүүнд улс төрийн албан тушаалтныг лалчлх хориглох;

3/сонгуулийн нутаг дэвсгэрийн, ийн хорооны бүрэлдэхүүний тоог тогтооход ын төлөөлөл, тухайн шатны иргэдийн өлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг ллзах;

4/сонгуулийн нутаг дэвсгэрийн н салбар, хэсгийн хороодын бүрэлдэхүүнд аль нэр дэвшүүлсэн намын төлөөлөл мгайлахыг хориглох бөгөөд сонгуульд хамтарч двшүүлсэн намуудын төлөөллийг нэг намын өлөлтэй адилтган тооцох;

5/Сонгуулийн ерөнхий хороо уулийн нутаг дэвсгэрийн хорооны, сонгуулийн дэвсгэрийн хороо харьяалах салбар, хэсгийн здын бүрэн эрхийг дуусгаар болгох хүртэлх аанд тухайн сонгуулийн хороод бүрэн эрхээ жүүлэх;

6/ Улсын Их Хурлаас баталсан уулийн хороодын гишүүний ёс зүйн дүрмийг мталж ажиллах;

7/сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нэр дэвшигчийн талаар сурталчилгаа хийхийг хориглох.

4. Сонгуулийн нутаг дэвсгэрийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно."

4/13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8, 9 дэх заалт:

"8/Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах салбар болон хэсгийн хороонд хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

9/сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцлэн архивлах, Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгөх;"

5/13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо харьяалах салбар болон хэсгийн хорооны хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгоно.

Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо энэ зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтыг зөрчиж Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн үүргийг удаа дараа биелүүлээгүй нь Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр тухайн сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо, түүний бүрэлдэхүүнийг өөрчлөн байгуулах үндэслэл болно."

6/15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Сонгуулийн хэсгийн хороог байгуулахдаа тухайн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан дор дурдсанаар тогтооно:

1/тухайн хэсэгт 2000 хүртэл сонгогчтой бол 9, эсхүл 11;

2/тухайн хэсэгт 2001-4000 хүртэл сонгогчтой бол 11, эсхүл 13;

3/тухайн хэсэгт 4001-6000 хүртэл сонгогчтой бол 13, эсхүл 15."

7/16 дугаар зүйлийн 2-6 дахь хэсэг:

"2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолд тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурах үүрэгтэй бөгөөд тэдний хэн нэг нь гарын үсэг зураагүй нь уг тогтоолыг хүчингүй, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

3. Сонгуулийн хороо хуралдааны дэгээ тогтоох бөгөөд түүнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчим, журмыг тусгасан байна.

4. Сонгуулийн хорооны хуралдааны тэмдэглэлийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу заавал хөтлөх бөгөөд түүнийг тухайн хорооны аль нэг гишүүнд хариуцуулна.

5. Сонгуулийн баримт бичиг бүртгэлтэй байх бөгөөд түүнд хамаарах баримт бичиг, түүнийг бүртгэх журмыг Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

6. Сонгуулийн нутаг дэвсгэрийн болон салбар хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана."

8/16 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

"11. Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо хуваарилагдсан төсвийн хөрөнгийн хэмжээнд сонгуулийг бэлтгэн явуулахдаа сонгон шалгаруулалтгүйгээр хувь хүн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллуулж болно."

9/26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Нам, сонгуульд хамтарсан намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, эсхүл улсуулагчийг сонгуулийн нутаг дэвсгэрийн хороонд 200 сонгогчид нэгээс илүүгүй байхаар тооцон Сонгуулийн ерөнхий хороо бүртгэж үнэмлэх олгоно."

10/31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг:

"1. Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам болон тэдгээрт тавигдах шаардлагыг санал хураах өдрөөс 21-ээс доошгүй хоногийн өмнө батална.

2. Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, нийслэлийн дүүргийн хэмжээнд нэгдсэн адил дугаартай байна."

11/31 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Сонгуулийн хороод саналын хуудсыг нийт бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүйг байлцуулан хүлээн авах ба энэ тухай тэмдэглэл үйлдэж, байлцсан бүх гишүүн гарын үсэг зурах бөгөөд хэрэв сонгуулийн хорооны аль нэг гишүүн уг тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгаан, үндэслэлээ бичгээр үйлдэж тухайн сонгуулийн хорооны даргад өгнө."

12/33 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

"6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дүрдьчилэн санал өгөх тохиолдол бүрт сонгуул хэсгийн хорооны нэг намын бус төлөөлөл хоёроос доошгүй гишүүн байлцах ба энэ тус тэмдэглэл үйлдэж, түүнд байлцсан сонгуул хэсгийн хорооны гишүүн бүр гарын үсэг зурна.

7. Санал хураах өдөр ажиллаж бай сонгогчид тухайн байгууллагын захиргаа чөл олгож, түүнийг санал өгөх боломжоор заавал хай үүрэгтэй."

13/35 дугаар зүйлийн 3-8 дахь хэсэг:

"3. Санал тоолох бэлтгэл хангагдм сонгуулийн хэсгийн хорооны дарга санал тос ажиллагаа явагдахыг зарлах ба сонгуулийн хэсг хороо уг ажиллагааг дараахь журмаар явуулн

1/санал өгсөн нийт сонгогчийн санал хураахад зарцуулсан саналын хууда тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцэ тооцоо гаргах;

2/санал хураахад зарцуулагда, үлдсэн болон буруу тэмдэглэл хийсэн хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тос бэрүүн дээд өнцгийг нь хайчлан, энэ тус тэмдэглэл хөтөлж, боож битүүмжлэх;

3/энэ хэсгийн 1, 2 дахь зааг заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа сана хайрцгийг нээж, саналыг тоолох;

4/санал тоолж дууссаны да санал хураалтын дүнг хэсгийн хэмжээгээр гар

4. Сонгуулийн хэсгийн хороо са хураалтын дүнг дараахь үзүүлэлтээр гаргана

1/сонгогчдын нэрийн жагсаал бүртгэгдсэн тухайн хэсгийн нийт сонгогчийн т

2/санал өгсөн нийт сонгогчийн үүнээс зөврийн битүүмжилсэн хайрцгаар би урьдчилан санал өгсөн сонгогчийн тоо;

3/саналын хайрцгаас гар хүчинтэй болон хүчингүй саналын хуудасны т

4/нэр дэвшигч бүрийн төлөө саналын тоо, хувь.

5. Санал хураахад зарцуулсан б зарцуулагдвалгүй үлдсэн саналын хууд нийлбэр нь тухайн сонгуулийн хэсгийн хоро хүлээн авсан нийт саналын хуудасны тос зөрвөл сонгуулийн хэсгийн хороо шалтга

глаж тогтоох бөгөөд зайлшгүй шаардлага гарвал алхын хуудсыг дахин тоолно.

6. Санал тоглох үед энэ зүйлийн 5 дахь зэгт заасан зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл үзэж, санал тоолох ажилд оролцогчдоор гарын г зуруулна.

7. Санал хураахад зарцуулсан нийт саналын дасны тоог саналын хайрцагас гарсан болон энэ лийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтад заасан алхын хуудасны нийлбэрээр тооцож гаргана.

8. Саналын хуудсанд огт тэмдэглэл гээгүй, эсхүл бүх нэр дэвшигчийн нэрийг дарсан алхын хуудсыг хүчинтэй саналын хуудаст цоож, хэнийг ч дэмжээгүй санал гэж үзнэ."

2 дугаар зүйл. Монгол Улсын өнхийлөгчийн сонгуулийн хуулийн 2, 3 дугаар лийн 1 дэх хэсгийн "Ерөнхийлөгчийн" гэсний өмнө нгол Улсын" гэж, 9 дүгээр зүйлийн "Сонгуулийг ал хураах өдрөөс" гэсний өмнө "1." гэж, 15 дээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтын "эмт бичгийг" гэсний дараа "Сонгуулийн өрөнхий ооноос баталсан журмын дагуу" гэж, мөн хэсгийн нь заалтын "гомдлыг" гэсний дараа "өөрийн эрх жээний хүрээнд" гэж, 16 дугаар зүйлийн 4 дэх лийн "сонгууль бэлтгэн" гэсний дараа "зохион суулж" гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн "албан алтан" гэсний дараа "эргэн" гэж, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Длоо" гэсний дараа "дээд шатны сонгуулийн оонд, эсхүл" гэж, 28 дугаар зүйлийн 2 дахь лийн "24 цагийн өмнө" гэсний дараа "буюу санал гах өдрийн өмнөх өдрийн 00 цагаас өмнө" гэж, дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "гуулийн хуулийг зөрчсөн нь" гэсний дараа лийн шийдвэрээр нотлогдсон бөгөөд энэ нь" гэж гус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын өнхийлөгчийн сонгуулийн хуулийн дараахь зүйл, зг, заалтыг дөр дурдсанаар өөрчлөн рүүлсугай:

1/3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн нь өгүүлбэр:

"Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн двэрээр нотлогдсон, түүнчлэн хорих ял эдэлж таа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх хгүй."

2/7 дугаар зүйл:

"7 дугаар зүйл. Сонгуулийн үйл плагааны эдийн засгийн баталгаа

1. Сонгууль зохион байгуулж явуулахтай богдсон дараахь зардлыг улсын төсвөөс үүжүүлнэ:

1/сонгогч, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, ухуулагч, сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогчийн шилжүүлэг, сонгуулийн дүн, мэдээний маягт, сонгуулийн нутаг дэвсгэрийн болон хэсгийн хороодын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, лац, тусгай тэмдэг тавих хэрэгсэл болон тэдгээрийг хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх зардал;

2/саналын хайрцаг хийлгэх, сонгуулийн хороодын ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал;

3/сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон журам, гарын авлага хэвлэх, хүргэх зардал;

4/сонгуулийн хороодын ажилтнуудын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;

5/сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд сурталчлах, сонгуулийн бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;

6/Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянахад гарах зардал;

7/сонгуулийн хороодын орон тооны бус гишүүний тухайн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшууллын зардал, хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн хорооны гишүүн сонгуулийн ажил үүргээ гүйцэтгэж явах үедээ эрүүл мэнд нь хохирсон, амь насаа алдсан тохиолдолд олгох нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламжийн зардал;

8/сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

9/Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

2. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

3. Сонгуулийн хороодын ажиллах, санал хураах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

4. Сонгуулийн хороодыг ажлын байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.

5. Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш 5 хоногийн дотор сонгуулийн зардлын сан байгуулж банкнд данс нээж, Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэж, нийтэд зарлах бөгөөд уг дансанд тухайн нэр дэвшигчийн өөрийн болон нэр дэвшүүлсэн намын хөрөнгө, талархан дэмжигч нам, байгууллага, иргэдээс оруулсан мөнгөн хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зарцуулна.

6. Талархан дэмжигч нам, байгууллага, иргэд сонгуульд зориулж мөнгөн хандив өргөж болох бөгөөд түүнийг сонгуулийн зардлын сангийн дансанд төвлөрүүлэх бөгөөд уг данснаас гадуур сонгуульд зориулж хандив авах, өгөх, зарцуулахыг хориглоно.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан хандивыг мөнгөн бус хэлбэрээр өгвөл түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэлж, мөн зүйлийн 9 дэх хэсэгт заасан хандивын дээд хэмжээний дүнд оруулан тосцно.

8. Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, нэр дэвшигч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсэгт заасан этгээдээс сонгуулийн ажилд зориулж хандив авах, түүнчлэн сонгууль бэлтгэн явуулах хугацаанд тусламжийн эд хөрөнгийг иргэдэд тараах буюу борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно.

9. Нэр дэвшигчийг талархан дэмжигчдээс сонгуульд зориулж өргөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс 10 сая, иргэдээс 5 сая төгрөгөөс хэтэрч болохгүй.

10. Сонгуулийн зардлын санг нэр дэвшигчийг сурталчлах, сонгогчидтой уулзах, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтны бичиг хэрэг, шуудан, холбоо, ажлын хөлс, урамшуулал, унааны болон албан томилогчийн зэрэг Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан журмаар зөвшөөрсөн бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

11. Сонгуулийн зардлын сангийн дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулах тухай тайлангийн загвар болон данс нээх, хаах, бүртгэл, тайланг хөтлөх журмыг Сонгуулийн ерөнхий хороо Монголбанктэй хамтран батална.

12. Нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллага нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

13. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн зардлын тайланг хянан үзэж, сонгууль дууссан өдрөөс хойш 40 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба таван зуун мянга, түүнээс дээш

төгрөгийн хандив өгсөн иргэн, нэг сая, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн нэриг нийтэд зарлана."

3/13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

"1. Сонгуулийн ерөнхий хороо сонгуули нутаг дэвсгэрийн хороог санал хураах өдрөөс 1 аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичиг дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, улс хэмжээнд нийтэд мэдээлнэ."

4/14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

"1. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хор суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүр сонгуулийн салбар хороог санал хураах өдрөөс 1 аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичиг дарга, 5 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ."

5/15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

"1. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хор сонгуулийн хэсгийн хороог санал хураах өдрөөс 1 аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичиг дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, ну дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ."

6/17 дугаар зүйл:

"17 дугаар зүйл. Сонгогчдын нэриг жагсаалт, түүнийг үйлдэх, танилцуулах

1. Сонгогчдын нэрийн жагсаалтад түүн үйлдэх үед сонгуулийн тухайн хэсэгт байгаа бүтүр оршин суугаа бүх сонгогчийн эрх /эх/-ийн нэр, нас, оршин суугаа газрын хаяг, иргэн үнэмлэхийн болон регистрийн дугаарыг бүрт бөгөөд ийнхүү бүртгэхдээ сонгогчийн нэрийг цаг, толгойн үслийн дарааллаар, эсхүл оршин суу газрын байршлаар нь аль тохиромжтой байдлыг дараалуулан бичнэ.

2. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг да тус тусын нутаг дэвсгэрт оршин суугаа сонгогч нэрийн жагсаалтыг хаягийн бүртгэлийн дэ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягт хоёр хувь үйлдэж санал хураах өдрөөс 30 хоног өмнө сонгуулийн хэсгийн хороонд өгнө.

Цагдаа, эмнэлэг, амралт, сувиллын газ эрх баригчид сонгогчдын нэрийн жагсаал үйлдэхэд шаардагдах мэдээллийг гаргаж үүрэгтэй.

3. Сонгуулийн хэсгийн хороо сонгогч нэрийн жагсаалтыг санал хураах өдрөөс 30 доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөн хорооноос баталсан маягтын дагуу хоёр :

үрөөноос баталсан маягтын дагуу хоёр хувь илдэж сонгуулийн хэсгийн хорооны дарга гарын гээ зурж, санал хураах өдрөөс 15-аас доошгүй иргэний өмнө, харин эмнэлэг, амралт, сувиллын зэргт 7 хоногийн өмнө ил тавьж сонгогчдод илвэртэй танилцах бололцоо олгоно.

4. Сонгогчдын нэрийн жагсаалт нь үндсэн зөвөрийн битүүмжилсэн хайрцагар санал хураах сэн төрөлтэй байна.

5. Сонгогч бүр сонгуулийн нэг хэсэгт нэрийн жагсаалтад бүртгэгдэх бөгөөд сонгуулийн нутаг өсгөрийн болон салбар хороо энэ зүйлийн 3 дахь зэгт заасны дагуу нэгтгэсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үндэслэн сонгогчдын тоог Сонгуулийн иөнхий хорооноос баталсан маягтын дагуу гтгэнэ.

6. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж шуруулах, тараахыг хориглоно.

7. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын рийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчид нгөгчийн үнэмлэх олгоно.

8. Сонгогчийн үнэмлэхэд сонгогчийн эцэг /ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон гистрийн дугаарыг бичнэ.

9. Сонгогчийн үнэмлэх аймаг, нийслэлийн үрэг тус бүрээр нэгдсэн индекс, дугаартай байна.

10. Сонгогчийн үнэмлэхийг сонгуулийн сгийн хорооны аль нэг гишүүн олгох бөгөөд эмлэхийг хүлээн авсан хүмээр гарын үсэг зуруулж галгаажуулна.

11. Сонгогчийн үнэмлэх олгосон сонгуулийн згийн хорооны гишүүний нэрийг сонгогчдын рийн жагсаалт дахь сонгогчийн нэрийн ард ддэглэнэ.»

7/19 дүгээр зүйл:

"19 дүгээр зүйл. Сонгогч шилжих

Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь зэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг йтдэ танилцуулж эхэлснээс хойш сонгуулийн рийн хороо саналын хуудас хүлээн авах хүртэлх ацванд сонгогч тодорхой шалтгаанаар өөр хэсэгт лжих бол шалтгаан, үндэслэлийг дурдсан зэлтийг сонгуулийн хэсгийн хороонд бичгээр рган шилжүүлэг авч, сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулж, очсон газрынхаа хаягаар нгөгчдын нэрийн жагсаалтад бүртгүүлнэ."

8/28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Нэр дэвшигчийн сонгуулийн галчилгааг нэр дэвшигч энэ хуулийн 23 дугаар йлийн 1-3 дахь хэсэгт заасны дагуу бүртгүүлж, млэх авсан өдрөөс эхлүүлнэ."

9/29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Нэр дэвшигч сонгогчидтой уулзахад нь айн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, бүх нэр шигчид тэгш хандах үүрэгтэй."

10/32 дугаар зүйл:

"32 дугаар зүйл. Санал хураах ажлыг зохион байгуулах

1. Санал хураах өдрийн 07 цагт сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан саналын бүх хайрцгийг нээж, шалган битүүмжилж лацдсаны дараа дараахь зүйлийг мэдээлнэ:

1/сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо;

2/хүлээн авсан, урьдчилан санал өгөхөд зарцуулсан, алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн саналын хуудасны тоо;

3/урьдчилан санал өгсөн сонгогчдын тоо, түүний явцад буруу тэмдэглэл хийснээс хүчингүй болсон саналын хуудасны тоо;

4/санал хураалтад ашиглах зөвөрийн битүүмжилсэн хайрцгийн тоо, түүгээр санал өгөх сонгогчийн тоо, санал хураах хуваарь;

5/хүлээн авсан, тараасан, буруу бичсэнээс хүчингүй болсон, алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн сонгогчийн үнэмлэхийн тоо.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад заасны дагуу урьдчилан өгсөн саналын тоог тусгайлан тэмдэглэж, тэдгээр саналын хуудсыг битүүмжилсэн дугтуйтай нь саналын хайрцагт хийнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан ажиллагаа, мэдээллийг нэг бүрчлэн тусгасан тэмдэглэл хөтлөх бөгөөд түүнд сонгуулийн хэсгийн хорооны нийт гишүүн гарын үсэг зурна.

4. Сонгуулийн хэсгийн хороо энэ зүйлийн 1-3 дахь хэсэгт заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал хураах ажлыг эхлүүлэх ба ингэхдээ сонгогчийн үнэмлэх, иргэний үнэмлэхийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрт саналын хуудас олгоно.

5. Саналын хуудас авсан сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсгээ зурж баталгаажуулна.

6. Саналаа өгсөн иргэний сонгогчийн үнэмлэхэд тусгайлан үүрэг хүлээсэн сонгуулийн хэсгийн хорооны гишүүн тэмдэглэл хийж, сонгуулийн хэсгийн хорооны тэмдэг дарах бөгөөд Сонгуулийн өрөнхий хорооноос тогтоосон тусгай тэмдэглэл хэрэглэж болно.

7. Санал хураах ажиллагаанд нэр дэвшүүлсэн намын сонгууль эрхэлсэн байгууллагаас томилсон ажиллагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

8. Санал хураах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд байхыг хориглох бөгөөд энэ нь тэдгээрээс саналаа өгөхөд хамаарахгүй.

9. Нэр дэвшүүлсэн намын сонгууль эрхэлсэн байгууллагаас томилсон ажиглагч нь санал хураах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.

10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн бол ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахаас татгалзана.

11. Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогчийн үнэмлэх бичих, санал хураах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянаж, дараахь эрх эдэлнэ:

1/сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;
2/саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах;

3/санал тоолох ажлыг ажиглах;
4/урьдчилан санал өгөх үйл ажиллагааг ажиглах;

5/зөөврийн битүүмжилсэн хайрцагар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал хураах чиглэл, хуваарьтай танилцах;

6/санал өгөх тасалгаа, саналын хайрцаг болон санал хураах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах

7/санал хураах байранд сонгуулийн санал хуралтын бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх;

8/санал хураах явцад зөрчил гарвал сонгуулийн хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, гэрчээр гарын үсэг зуруулах;

9/сонгуулийн хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах;

10/ажиглалтын тайлангаа нийтэд танилцуулах.

12. Ажиглагч энэ зүйлийн 11 дэх хэсэгт заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл олон нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж, сонгуулийн хорооны ажилд хөндлөнгөөс оролцвол сонгуулийн хэсгийн хороо түүний ажиглагчийн эрхийг хүчингүй болгож, урьд олгосон үнэмлэхийг хураан авна.

13. Ажиглагч энэ зүйлийн 12 дахь хэсэгт заасны дагуу эрхээ хасуулсан бол түүнийг санал болгосон нам, нэр дэвшигч нь орны хүнийг томилхо эрхгүй бөгөөд ийм хүсэлт гаргавал сонгуулийн хороод хүлээн авахаас татгалзана.

14. Гадаадын ажиглагч, түүнчлэн аливаа хэвлэл, мэдээллийн хэрэгсэл сонгуулийг ажиглах, сурвалжлахтай холбогдсон журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталж мөрдүүлнэ."

11/33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Сонгогч санал хураах байранд ирж саналаа өөрөө өгөх бөгөөд харин биеийн эрүү мэндийн байдлын улмаас санал хураах байран хүрэлцэн ирж чадахгүй сонгогч зөөврийн битүүмжилсэн хайрцагар санал өгөх хүсэлтэ санал хураах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд бичгээр гарга бөгөөд тухайн сонгогчийн саналыг сонгуулий хэсгийн хорооны нэг намын бус төлөөлөлтэ хоёроос доошгүй гишүүн оршин суугаа газры хаягаар очиж авна."

12/34 дүгээр зүйлийн 4, 5 дахь заалт:

"4/энэ хуульд зааснаас өөр тэмдэглэ хийснээс аль нэр дэвшигчид санал өгснийг тодорхойлох боломжгүй болсон;

5/нэр дэвшигчийн нэрийн өмнө тавьса дугаарыг засварласнаас аль нэр дэвшигчид санал өгснийг тодорхойлох боломжгүй болсон."

4 дүгээр зүйл. Монгол Улсы Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 1 дүгээ зүйлийн "бэлтгэн" гэснийг "зохион байгуулж" гэ 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "ажлын 10 өдрийг дотор" гэснийг "ажлын 7 өдрийн дотор" гэж, мэ зүйлийн 4 дэх хэсгийн "ажлын 5 өдрийн дотор" гэснийг "ажлын 3 өдрийн дотор" гэж, 28 дугаа зүйлийн 3 дахь хэсгийн "Монголын үндэсний ради телевизээр" гэснийг "улс даяар үйл ажиллага явуулж байгаа бүх радио, телевизээр" гэж, 8 дугаа зүйлийн 11 дэх хэсгийн дугаарыг "24" гэж, 1 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт дугаарыг "10" гэж, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсги дугаарыг "3" гэж, 16 дугаар зүйлийн 2-5 да хэсгийн дугаарыг "7-10" гэж, 31 дүгээр зүйлийн 1-дахь хэсгийн дугаарыг "3-5" гэж, 35 дугаар зүйли 4 дэх хэсгийн дугаарыг "9" гэж тус тус өөрчилсүгэ

5 дугаар зүйл. Монгол Улсы Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 16 дугаа зүйлийн 1 дэх хэсгийн "Сонгуулийн ерөнхий хоро нутаг дэвсгэрийн болон салбар хорооны дар дотоод ажлын асуудлаар захирамж гаргана." гэс 3 дахь өгүүлбэрийг, 28 дугаар зүйлийн 5 да хэсгийн "Зөвхөн нэр дэвшигчийн сурталчилга орон даяар эхлэх, дуусахад зориулж нийслэ аймгийн төвүүдэд урлагийн тоглолтыг н: дэвшүүлсэн намаас зохион байгуулж болно." гэс 2 дахь өгүүлбэрийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Монгол Улсы Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 8 дугаа зүйлийн 3-10 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 3 да хэсэг, 35 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус т хүчингүй болгонд тооцугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдс өдрөөс нь буюу 2009 оны 01 дүгээр сарын 16-й өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДДЭМБЭРС



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

09 оны 01 дүгээр
рын 16-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.
 1. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын
 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Улийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, санал

раалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их

рлаас ТОГТООХ нь:

1. Батаагийн Баттулга, Батчулууны

ярсайхан нарыг Сонгуулийн ерөнхий хорооны

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

09 оны 01 дүгээр
рын 16-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай Содномцэрэн нарыг тус тус томилсугай.
 1. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын
 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Улийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, санал

раалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их

рлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр

мсрайжавын Лувсанжав, Чойнзонгийн

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

09 оны 01 дүгээр
рын 17-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас тус
 тус чөлөөлсүгэй.

Улийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, санал

раалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их

рлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс

лөөлсөнтэй нь холбогдуулж Батаагийн

ттулгыг Сонгуулийн ерөнхий хорооны даргын,

тчулууны Баярсайханыг Сонгуулийн ерөнхий

2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын
16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

09 оны 01 дүгээр
рын 17-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай ерөнхий хорооны гишүүн Чойнзонгийн
 Содномцэрэнг тус тус томилсугай.

Улийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, санал

раалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их

рлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны даргаар

нгуулийн ерөнхий хорооны гишүүн Намсрайжавын

асаажавыг, нарийн бичгийн даргаар Сонгуулийн

2. Энэ тогтоолыг 2009 оны 01 дүгээр сарын
16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ГАДААДЫН АЛБАН ЁСНЫ БИЧИГ БАРИМТЫГ БАТАЛГААЖУУЛАХ ШААРДЛАГЫГ ХАЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ*

Энэхүү конвенцид гарын үсэг зурагч улсууд нь, Гадаадын албан ёсны бичиг баримтад дипломат буюу консулын баталгаа хийх шаардлагыг халахыг эрмэлзэн,

Энэ зорилгоор конвенц байгуулахаар шийдвэрлэж, дараахь зүйлийг харилцан тохиролцов:

1 дүгээр зүйл

Энэхүү конвенц нь Хэлэлцэн тохирогч нэг улсын нутаг дэвсгэр дээр үйлдэж Хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэр дээр хэрэглэх албан ёсны бичиг баримтад үйлчилнэ.

Энэхүү конвенцийн зорилгоор дараахь бичиг баримтыг албан ёсны гэж үзнэ:

- a) тухайн улсын шүүх буюу хэрэг хянан шийдвэрлэх байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, тухайлбал улсын прокурор, шүүхийн нарийн бичгийн дарга эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэгч ("huissier de justice")-ийн үйлдсэн бичиг баримт;
- b) төрийн захиргааны байгууллагын бичиг баримт;
- c) нотариатын үйлдэл;
- d) бичиг баримтыг бүртгэлд бүртгэсэн тухай, эсхүл бичиг баримт тодорхой цаг үед албан ёсны байсан баримтыг бүртгэсэн тухай болон түүнд зурсан гарын үсгийг нотариатаар гэрчилсэн тухай гэрчилгээ зэрэг хувийн эрх хэмжээнийхээ хүрээнд аливаа этгээдийн гарын үсэг зурж бичиг баримтад хавсаргасан албан ёсны гэрчилгээ.

Гэхдээ энэхүү конвенц дараах бичиг баримтад үйлчлэхгүй:

- a) дипломат болон консулын төлөөлөгчийн үйлдсэн бичиг баримт;
- b) худалдааны болон гаалийн үйл ажиллагаатай шууд холбоотой захиргааны бичиг баримт.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүрт энэхүү конвенц үйлчлэх бөгөөд нутаг дэвсгэрт нь хэрэглэх бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг хална. Энэхүү конвенцийн хүрээнд "баталгаажуулалт" гэж бичиг баримтад зурсан гарын үсэг жинхэнэ эсэх, гарын үсэг зурсан этгээд нь ийм эрх мэдэлтэй эсэх, шаардлагатай тохиолдолд бичиг баримтад дарсан тамга, тэмдэг үнэн зөв болохыг тухайн бичиг баримт хэрэглэгдэх орны дипломат буюу консулын төлөөлөгч нотлон гэрчлэх албан ёсны үйлдлийг хэлнэ.

3 дугаар зүйл

Гарын үсэг жинхэнэ эсэх, гарын үсэг зурсан этгээд нь ийм эрх мэдэлтэй эсэх, шаардлагатай тохиолдолд бичиг баримтад дарсан тамга, тэмдэг үнэн зөв болохыг нотлон гэрчлэхийн тулд тухайн бичиг баримт үйлдэгдсэн улсын эрх бүхий байгууллагаас 4 дүгээр зүйлд заасан гэрчилгээг олгох шаардлага тавигдана.

Гэхдээ тухайн бичиг баримт хэрэглэгдэх улсад мөрдөж буй хууль, журам болон практик, эсхүл Хэлэлцэн тохирогч хоёр буюу түүнээс дээш улстай байгуулсан гэрээгээр дээр дурдсан шаардлагыг халсан, хөнгөвчилсөн, эсхүл тухайн

бичиг баримтыг баталгаажуулахаас чөлөөтсөн бол уг шаардлагыг тавихгүй байж болно.

4 дүгээр зүйл

3 дугаар зүйлийн эхний хэсэгт зааса гэрчилгээг бичиг баримт дээр, эсхүл түүн, хавсаргасан өөр хуудсан дээр үйлдэж олгох бөгөөд уг гэрчилгээ нь энэхүү конвенцид хавсаргаса загварын хэлбэртэй байна.

Гэхдээ гэрчилгээг олгож байгаа улсы албан ёсны хэлээр үйлдэж болно. Гэрчилгээг тусгагдах стандарт заалтуудыг мөн өөр хэлээ үйлдэж болно. "Apostille" гэсэн гарчиг нь (Convention de La Haye du 5 octobre 1961) заавал франц хэлээ байна.

5 дугаар зүйл

Гэрчилгээг бичиг баримтад гарын үсг зурсан этгээдийн, эсхүл түүнийг эзэмшигчий хүсэлтээр олгоно.

Зохих журмын дагуу бөглөгдсөн гэрчилгээ нь гарын үсэг жинхэнэ эсэх, гарын үсэг зурса этгээд нь ийм эрх мэдэлтэй эсэх, шаардлагата тохиолдолд бичиг баримтад дарсан тамга, тэмдг үнэн зөв болохыг нотлон гэрчилнэ.

Гэрчилгээнд зурсан гарын үсэг, дарса тамга, тэмдгийг бүх төрлийн баталгаажуулалтаа чөлөөлнө.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр 3 дугаа зүйлийн эхний хэсэгт заасан гэрчилгээг олгох эр бүхий байгууллагыг албан ёсны чиг үүрэгтэй н уялдуулан томилно.

Хэлэлцэн тохирогч улс бүр конвенций соёрхон баталсан болон нэгдэн орсон батлам жуух бичиг, эсхүл өөр улсад үйлчлэх болсон туха мэдэгдлийг гардуулахдаа ийм байгууллагы томилсон тухайгаа Нидерланд Улсын Гадаа хэргийн яаманд мэдэгдэнэ. Түүнчлэн томилогдсс эрх бүхий байгууллага өөрчлөгдвөл мөн мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

6 дугаар зүйлд заасны дагуу томилогдсс эрх бүхий байгууллага бүр нь олгосон гэрчилгээ бүртгэсэн бүртгэл эсхүл картан сан хөтөлб дараахь зүйлийг тусгана:

- a) гэрчилгээний дугаар болон олгосон он, сар, өдөр
- b) албан ёсны бичиг баримтад гарын үсэг зурса этгээдийн нэр, түүний ийнхүү гарын үсэг зурсан эр мэдэл, эсхүл гарын үсэг зурагдаагүй бичи баримтын хувьд түүнд тамга, тэмдэг дарсан эр бүхий байгууллагын нэр.

Гэрчилгээ олгосон эрх бүхий байгуулла нь сонирхогч аливаа этгээдийн хүсэлтээ шалгуулахыг хүссэн гэрчилгээг өөрийн бүртгэ эсхүл картан сантай тулган шалгаж өгнө.

8 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр болон түүнээс дээш улсын хооронд байгуулсан гэрээ, конвенц

*Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай Монгол Улсын хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2009 оны 3 дугаарт нийтлэгдсэн.



лон хэлэлцээр нь гарын үсэг, тамга, тэмдгийг галгаажуулах талаар энэхүү конвенцийн 3, 4 тээр зүйлд зааснаас илүү өндөр шаардлага всан заалттай бол энэ конвенц зөвхөн тэдгээр алтыг хүчингүй болгоно.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр энэхүү конвенцийн дагуу баталгаажуулах шаардлагаас илөөлсөн бичиг баримтыг дипломат болон исулын төлөөлөч нь баталгаажуулахгүй байх паар шаардлагагай арга хэмжээг авна.

10 дугаар зүйл

Энэхүү конвенц нь Олон улсын хувийн эрх йн Гаагийн бага зурлын есдүгээр чуулганд юлцогч улсууд болон Исланд, Ирланд, ихштенштейн, Турк Улсын хувьд гарын үсэг рахад нээлттэй байна.

Энэхүү конвенцийг соёрхон батлах бөгөөд ёрхон баталсан тухай батламж жуух бичгийг дерланд Улсын Гадаад хэргийн яаманд далуулна.

11 дүгээр зүйл

Энэхүү конвенц нь 10 дугаар зүйлийн хоёр хь хэсэгт заасан соёрхон баталсан тухай гурав хь батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш р дахь өдөр хүчин төгөлдөр болно.

Түүнээс хойш соёрхон баталсан гарын үсэг ээгч улс бүрийн хувьд энэхүү конвенц нь соёрхон талсан тухай батламж жуух бичгээ цгалуулснаас хойш жар дахь өдөр хүчин төгөлдөр лно.

12 дугаар зүйл

дугаар зүйлд дурдагдаагүй аливаа улс энэхүү вененц 11 дүгээр зүйлийн эхний хэсэгт заасны гуу хүчин төгөлдөр болсны дараа энэхүү вененцид нэгдэн орж болно. Нэгдэн орсон тухай чиг баримтыг Нидерланд Улсын Гадаад хэргийн манд хадгалуулна.

Ийнхүү нэгдэн орсон нь нэгдэн орж буй улс лон 15 дугаар зүйлийн "д"-д заасан мэдэгдлийг лээн авснаас хойш зургаан сарын дотор тухайн сыг нэгдэн орсныг нь эсэргүүцээгүй Хэлэлцэн кирогч улсуудын хоорондын харилцаанд зөвхөн рчилнэ. Нэгдэн орсныг нь эсэргүүцэж байгаагаа дерланд Улсын Гадаад хэргийн яаманд дэгдэнэ.

Энэхүү конвенц нь нэгдэн орж буй улс лон тухайн улсыг нэгдэн орсныг нь эсэргүүцээгүй суудын хооронд дээр дурдсан зургаан сарын тацаа өнгөрснөөс хойш жар дахь өдөр хүчин өлдөр болно.

13 дугаар зүйл

Аливаа улс гарын үсэг зурах, соёрхон глах, эсвэл нэгдэн орохдоо энэхүү конвенц нь он улсын харилцаанд төлөөлж буй түүний бүх юу тодорхой хэсэг нутаг дэвсгэрт үйлчилнэ гэж дэгдэж болно. Ийм мэдэгдэл нь тухайн улсын ьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон рөөс хүчинтэйд тооцогдоно.

Үүнээс хойш ийм мэдэгдлийг хэдийд ч хийж лох бөгөөд энэ тухайгаа Нидерланд Улсын даад хэргийн яаманд мэдэгдэнэ.

Нутаг дэвсгэрт нь үйлчлэх тухай мэдэгдлийг конвенцид гарын үсэг зурж, соёрхон баталсан улс гаргавал конвенц нь тухайн нутаг дэвсгэрийн хувьд 11 дүгээр зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болно. Хэрэв нутаг дэвсгэрт нь үйлчлэх тухай мэдэгдлийг конвенцид нэгдэн орсон улс гаргавал конвенц нь тухайн нутаг дэвсгэрийн хувьд 12 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болно.

14 дүгээр зүйл

Энэхүү конвенц нь 11 дүгээр зүйлийн эхний хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд энэ нь конвенц хүчин төгөлдөр болсноос хойш түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон улсуудын хувьд ч нэгэн адил үйлчилнэ. Энэхүү конвенцийг цуцлаагүй тохиолдолд түүний хүчинтэй байх хугацаа нь тав, таван жилээр аяндаа сунгагдана.

Энэхүү конвенцийг цуцлах тухайгаа Нидерланд Улсын Гадаад хэргийн яаманд тухайн таван жилийн хугацаа дуусахаас өмнө наад зах нь зургаан сарын өмнө мэдэгдэнэ.

Цуцлалт нь конвенц үйлчилж буй зарим нутаг дэвсгэрт хязгаарлагдаж болно.

Цуцлалт нь зөвхөн конвенцийг цуцалсан тухайн улсын хувьд л үйлчилнэ.

Хэлэлцэн тохирогч бусад улсын хувьд энэхүү конвенц нь хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

15 дугаар зүйл

Нидерланд Улсын Гадаад хэргийн яам нь 10 дугаар зүйлд дурдсан улсууд болон 12 дугаар зүйлд заасны дагуу нэгдэн орсон улсуудад дор дурдсан зүйлсийн талаар мэдэгдэл өгөх үүрэгтэй:

- a) 6 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт заасан мэдэгдэл;
 - b) 10 дугаар зүйлд заасны дагуу гарын үсэг зурсан болон соёрхон баталсан тухай мэдэгдэл;
 - c) 11 дүгээр зүйлийн эхний хэсэгт заасны дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болох он, сар, өдөр;
 - d) 12 дугаар зүйлд заасны дагуу нэгдэн орсон болон эсэргүүцсэн тухай мэдэгдэл болон ийнхүү нэгдэн орсон нь хүчин төгөлдөр болох он, сар, өдөр;
 - e) 13 дугаар зүйлд заасны дагуу нутаг дэвсгэрт нь үйлчлэх тухай мэдэгдэл болон уг мэдэгдэл хүчин төгөлдөр болох он, сар, өдөр;
 - f) 14 дүгээр зүйлийн гурав дахь хэсэгт заасны дагуу цуцлах тухай мэдэгдэл.
- ХЭМЭЭСНИЙГ НОТЛОН зохих ёсоор эрх олгогдсоны дагуу энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү конвенцийг Гааг хотноо 1961 оны 10 дугаар 5-ны өдөр франц, англи хэлээр тус тус нэг эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх бичвэрийн хооронд зөрүү гарвал франц хэлээр эх бичвэрийг баримтална. Эх бичвэрийг Нидерланд Улсын Засгийн газрын архивт хадгалах бөгөөд баталгаат хуулбарыг нь Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын есдүгээр чуулганд оролцогч улсууд болон Ирланд, Исланд, Лихтенштейн, Турк Улсад дипломат шугамаар илгээнэ.



КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТ

Гэрчилгээний загвар

Гэрчилгээ нь дөрвөлжин хэлбэртэй байх бөгөөд гал бүр нь 9 сантиметрээс доошгүй урттай байна

APOSTILLE

(Convention de La Haye du 5 Octobre 1961)

1. Улс:

Энэхүү албан ёсны бичиг баримтад:

- 2. гарын үсэг зурсан зүүний озог, нэр
- 3. албан тушаал:
- 4. тамга, тэмдэг дарсан байгууллагын нэр

Баталгаажуулсан

- 5. хот 6. огноо
- 7. баталгаажуулсан байгууллагын нэр
- 8. дугаар
- 9. тамга/тэмдэг 10. гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 262420
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1.5